

ҮСХ-ны даргын 2013 оны  
12 дугаар сарын 06-ны өдрийн  
1/135 тоот тушаалын хавсралт

# **Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал**

**Улаанбаатар хот**

**2013 он**

# Агуулга

I. Нийтлэг үндэслэл

II. Ядуурлын тухай ойлголт, тодорхойлолт

III. Ядуурлын статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр

III.1. Аж байдлын үзүүлэлтийн сонголт

III.2. Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоох

III.2.1. Хэрэглээг бүрдүүлэхэд баримтлах үндсэн зарчмууд

III.2.2. Хүн амын хэрэглээний хэмжээг хэрэглээний дэд бүлгээр тодорхойлох

III.3. Үнийн зохицуулалт

III.4. Өрхийн хэрэглээний бүтэц, хэмжээнд зохицуулалт хийх

III.5. Ядуурлын шугам тооцох арга

III.6. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох

III.7. Мэдээллийн эх үүсвэр, мэдээллийн боловсруулалт, тооцоонд хэрэглэгдэх үндсэн ангилал

## **I. Нийтлэг үндэслэл**

Хүн амын амьжиргааны түвшин, ялангуяа ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын жишиг аргачлалд нийцүүлэн, үндэсний онцлогийг тусгасан нэгдсэн аргачлалаар тодорхойлж, бодлого боловсруулагч, судлаач, шинжээч нарыг холбогдох мэдээллээр хангахад энэхүү аргачлалын зорилго оршино.

Хүн амын аж байдлын талаарх эдийн засгийн хэмжигдэхүүнүүдийг ядуурлын дүн шинжилгээнд ашиглахын тулд, мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн ядуурлын хэмжигдэхүүнүүдийг үндэс болгодог. Мөнгөн дүнгээр илэрхийлж байгаа энэхүү үзүүлэлтүүд нь хүн амын аж байдлын бүх талын хүрээг хамарч чадахгүй ч амьжиргааны түвшний үнэлгээний үндсэн гол хэсгийг илэрхийлнэ. Ядуурлын байдлыг мөнгөн дүнгээр илэрхийлж тодорхойлох нь хүний амьдралын материаллаг байдлын түвшин дээр үндэслэнэ. Энэ арга зүй, хэмжигдэхүүнүүд нь хэрэглэгчдэд ашиглахад ойлгомжтой, үндэслэлтэй, тоон мэдээллээр баталгаажсан байх боломжийг агуулсан байдаг.

## **II. Ядуурлын тухай ойлголт, тодорхойлолт**

Ядуурал нь хувь хүний аж байдлын доройтол, хомсдолтой байдлаар илрэх бөгөөд эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавхи доройтох, хоол тэжээлийн хомсдол, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж хязгаарлагдмал байх, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байх зэргээр илэрдэг.

Ядуурлын статистикт туйлын (абсолют), харьцангуй гэсэн үндсэн хоёр ойлголт давамгайлдаг. Туйлын (абсолют) ядуу гэж амьжиргааны наад захын зайлшгүй хэрэглээнээс доогуур хэрэглээтэй хүн амыг хэлнэ. Харьцангуй ядуу гэж тухайн хүн өөрийн хэрэгцээгээ хэрхэн үнэлж, бусадтай харьцуулж байгаагаар буюу хэрэгцээгээ өөрийн нөөц боломжтойгоо уялдуулан харьцуулж гаргасан дүгнэлтээр ядуу гэж тодорхойлж байгааг хэлнэ. Туйлын ядууралд амьжиргааны наад захын зайлшгүй хэрэгцээг голлон судалдаг бол харьцангуй ядуурал нь орлого, баялгийн хуваарилалт болон ядуучуудыг нийгмийн бусад бүлэг, давхаргатай харьцуулан судална.

Манай орны нөхцөлд хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тооцохдоо олон улсын практикт, ялангуяа хөгжиж байгаа орнуудад өргөн хэрэглэгддэг “туйлын (абсолют) ядуурал”-аар тооцож тодорхойлно. “Туйлын (абсолют) ядуурал”-ыг “хэрэглээний сагсны арга”-ыг ашиглан тооцоход энэхүү аргачлалыг үндэс болгож байна. Хэрэглээний сагсыг бүрдүүлж байгаа бараа, үйлчилгээний нэр, төрөл, хэмжээ нь манай улсын онцлог, хүн амын насны бүлэг зэргээс хамаарч ялгаатай байна.

### **III. Ядуурлын статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр**

#### **III.1. Аж байдлын үзүүлэлтийн сонголт**

Ядуурлын дүн шинжилгээнд дараах үндсэн 3 шаардлагыг хангасан статистик үзүүлэлтүүдийг хэрэглэнэ. Үүнд:

1. Хүн амын аж байдлыг илэрхийлэх, хэмжигдэх, хүлээн зөвшөөрөгдөхүйц гэхдээ хүн амыг тодорхой шалгуураар эрэмбэлэх боломжтой хэмжигдэхүүн байна.

2. Хүн амыг ядуу ба ядуу бус гэж ангилж, сонгогдсон үзүүлэлтүүдтэй харьцуулах боломжтой хэмжигдэхүүн /ядуурлын шугам/ байна.

3. Аж байдлын үзүүлэлтүүдийг ядуурлын нэгдсэн дүр төрхөд шилжүүлэх боломжтой хэмжигдэхүүн байна.

Ядуурлын дүн шинжилгээнд амьжиргааны түвшинг тодорхойлох эдийн засгийн хэмжигдэхүүнийг тогтмол ашиглаж байгаа бөгөөд мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжигдэхүүнийг үндэслэн хүн амын амьжиргааг тооцох суурь үзүүлэлт болон хугацааг тодорхойлно. Суурь үзүүлэлт нь орлого, хэрэглээний үзүүлэлтийн аль нэг нь байна. Орлого, хэрэглээ хоёрын алиныг нь аж байдлын хэмжүүр үзүүлэлт болгож сонгож авахыг шийдэх нь юуны түрүүнд чухал юм. Хэрэглээ нь хувь хүн бүр бодитоор юу хэрэглэснийг илэрхийлдэг бол орлого нь тухайн хүний чадварыг хөрөнгийн хамт хэмжинэ. Орлогын үзүүлэлттэй харьцуулахад хэрэглээ нь тогтвортой, улирлын хэлбэлзэл багатай байдаг учир ядуурлын байдлыг бодитойгоор илэрхийлнэ. Онолын хувьд ч мөн практик дээр ч амьжиргааны түвшинг хэрэглээгээр тодорхойлох нь орлогоор тодорхойлсноос илүү зохимжтой байдаг. Богино хугацааны буюу жишээ нь нэг жилийн хувьд орлогыг бодвол хэрэглээ нь илүү тогтвортой, өөрчлөлт багатай байдаг ба мэдээлэгчдэд хэрэглээгээр тодорхойлох нь орлогоос илүү хялбар байдаг зэрэг шалтгаанаар манай орны нөхцөлд хэрэглээний үзүүлэлтийг сонгож ядуурлын тооцоог хийнэ. Ядуурлыг хэмжих, тодорхойлох үзүүлэлтүүд нь бие биенээсээ харилцан хамаарал бүхий олон үзүүлэлтийн цогц байна. Энэ олон хэмжүүрүүдийг бүрдүүлэхэд тодорхой зарчмыг баримтална.

#### **III.2. Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоох**

##### **III.2.1. Хэрэглээг бүрдүүлэхэд баримтлах үндсэн зарчмууд**

1. Хэрэглээг илэрхийлэгч мэдээллийн бүх боломжит эх үүсвэрүүдийг хамруулна. Үүнд:

*а. Худалдан авсан, гэрээс гадуур хэрэглэсэн хэрэглээ*

*б. Өрхийн хувийн аж ахуйгаасаа болон байгалиас үнэгүй авч хэрэглэсэн хэрэглээ*

*в. Бусдаас авсан бэлэг, тусламж, солилцоогоор авсан зүйлс*

г. Зах зээлийн болон зах зээлийн бус гүйлгээ (Жишээ нь: түрээс удаан эдэлгээтэй бараа, тээвэр, холбоо, цахилгаан эрчим хүч, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ);

2. Хэрэглээнд зөвхөн өрхийн хэрэглэсэн бараа үйлчилгээг хамруулна.
3. Хэрэглэсэн бараа үйлчилгээ бүрийн үнийн нөлөөллийг тодорхойлно. Тооцооны үнийн нөлөөллийг багасгахын тулд улирлын болон бусад нөлөөллийг харгалзан түүврийн шатуудад /түүврийн анхан шатны нэгж, суурьшил, бүсийн, улирлын гэх мэт/ үнийн медиан утгыг ашиглана.
4. Худалдан аваагүй боловч хэрэглэсэн хүнсний болон хүнсний бус зүйлийн нэр төрлүүдийн үнийн дүнг (мөнгөн бус хэлбэрээр худалдан авсан мөн худалдан аваагүй хэрэглээг мөнгөн дүнд шилжүүлэхийн тулд тухайн нэрийн бараа, үйлчилгээний хэмжээг худалдан авалтын нээжийн медиан үнээр үржүүлж тодорхойлно) тодорхойлж, хэрэглээний мөнгөн дүнд хамруулна.
5. Өрхийн гишүүдийн дундын хэрэглээний бараа, үйлчилгээ ихэнхдээ хүнсний бүтээгдэхүүний хувьд худалдан авалтыг бүтнээр нь хэрэглээ гэж үзэх ба сууц, удаан эдэлгээтэй барааны хэрэглээг тодорхойлоход тодорхой зохицуулалтыг хийнэ.
6. Хэрэглээний хэмжээг тодорхойлоход хамруулж байгаа хэрэглээ тус бүрийн хамралтын хугацаа ижил байна (7 хоног, сар, улирал, жил, сүүлийн сар, 12 сар гэх мэт).

### III.2.2. Хүн амын хэрэглээний хэмжээг хэрэглээний дэд бүлгээр тодорхойлох

**Хэрэглээний бүтэц, бүрэлдэхүүн:** Хэрэглээ нь дараах 5 дэд бүлгээс бүрдэнэ.

- Үүнд:
1. Хүнсний хэрэглээ
  2. Хүнсний бус хэрэглээ
  3. Сууцны хэрэглээ
  4. Удаан эдэлгээтэй барааны хэрэглээ
  5. Түлш, эрчим хүчний хэрэглээ

Хэрэглээний дэд бүлэг тус бүр хэрэглээний тодорхой нэр төрлүүдээс бүрдэх ба эдгээр нэр төрөл бүрийн хэрэглээний үнэлгээг тодорхойлох өөр өөрийн аргачлалтай байна. Үүнд:

1. Хүнсний хэрэглээ Хүнсний хэрэглээний хэмжээг тодорхойлохдоо нэгдсэн нэг цаг хугацаанд шилжүүлэн хүнсний бүх бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийн хэрэглээг бүрдүүлэх бөгөөд өрх бүрийн бүх хүнсний барааны хэрэглээг нэгтгэнэ. Хэрэглээний энэ бүрэлдэхүүн хэсгийг боловсруулахад хэд хэдэн үндсэн зарчмыг баримтална. 1-рт, Хэрэглээний бүх боломжит эх үүсвэрийг хамруулна. Өөрөөр хэлбэл хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ нь зах зээлээс худалдан авсан, гэрээс гадуур хэрэглэсэн, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн, бусдаас авсан бэлэг, бараа солилцоогоор авч хэрэглэсэн бүтээгдэхүүн зэргээс бүрдэнэ. 2-рт, Худалдан авсан болон өөрийн аж ахуйгаас авсан бүх

бүтээгдэхүүнийг бус зөвхөн судалгаа авсан тухайн хугацаанд өрхийн гишүүдийн хэрэглэсэн бүтээгдэхүүнүүдийг л хэрэглээний бүтцэд хамруулна. 3-рт, Мөнгөөр худалдан аваагүй хүнсний зүйлийг үнэлж оруулна. Судалгаагаар өрхийн хүнсний хэрэглээний зөвхөн худалдан авалтын хувьд үнийн дүн, тоо хэмжээний талаар мэдээлэл цуглуулдаг бөгөөд худалдан аваагүй хүнсний зүйлийн үнийг тооцохдоо уг үнийн мэдээллийг ашиглана. Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл тус бүр дээр хэд хэдэн түвшинд (өрх, түүврийн нэгж, аймаг, суурьшил, улирал) үнийн медиан утгыг тооцно. Тухайн өрх хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан бол уг худалдан авсан барааны харгалзах медиан үнийг өөрийн аж ахуйн болон солилцоогоор, эсвэл үнэгүй авч хэрэглэсэн барааг үнэлэхэд ашиглана. Хэрвээ өрх тухайн нэр төрлийн барааг огт худалдан аваагүй боловч хэрэглэсэн бол хэрэглээг нь үнэлэхэд өрхийн харьяалагдах түүврийн нэгжийн медиан үнийг ашиглана. Хэрвээ түүврийн нэгжид тухайн нэр төрлийн барааны худалдан авалт хийгдээгүй бол аймаг, орон нутгийн харьяалагдах нэгжийн медиан үнийг ашиглана. Ерөнхийдөө хүнсний хэрэглээний дүнг тооцохдоо өрхийн хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн тус бүрийн биет хэмжээг харгалзах нэгжийн үнэ(медиан үнэ)-ээр үржүүлж тооцох бөгөөд уг хүнсний бүтээгдэхүүн тус бүрийн үржвэрийг өрхийн түвшинд нэмж, өрхийн нийт хүнсний хэрэглээг тооцно.

2. Хүнсний бус хэрэглээ Хүнсний бус хэрэглээний хэмжээг тодорхойлохдоо хүнсний хэрэглээтэй адилаар нэгдсэн нэг хугацаанд шилжүүлэн тэгшитгэсэн хэрэглээний бүх эх үүсвэрийг оруулна. Хүнсний бус хэрэглээнд хувцас, гутал, гоо сайхны бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, амралт, чөлөөт цаг, эрүүл мэнд, боловсролд зарцуулсан зардал гэх мэт зүйлс хамаарна. Татварын хэмжээ, санхүү, хөрөнгийн гүйлгээ, өр, зээлийн хүүгийн төлбөрийг энд оруулахгүй. Бөөн дүнгээр зарцуулагддаг хурим, найр, баяр ёслол, оршуулгын зардлыг тооцоонд оруулахгүй. Бусдад өгсөн эсвэл хүлээн авсан бэлэг, дурсгал, шилжүүлгийг давхардуулахгүй буюу зөвхөн хүлээн авагч талын тооцоонд тусгана. Эрүүл мэнд, боловсролын зардлыг хэрэглээний бүтцэд оруулж тооцно. Хэрэв тухайн өрх сүүлийн нэг сард хүнсний бус бараа, бүтээгдэхүүн худалдан авсан бол тухайн мэдээллийг нь авч, харин сүүлийн нэг сарын хугацаанд хүнсний бус бараа бүтээгдэхүүн худалдан аваагүй бол сүүлийн нэг жилийн мэдээллийг сард шилжүүлэн авдаг. Бусдаас үнэгүй авсан хэрэглээг мөн сард шилжүүлэх бөгөөд худалдан авалтын дүн дээр нэмж тооцоонд оруулна. Ингээд хүнсний бус хэрэглээний дүн нь бараа бүтээгдэхүүн тус бүрийн хэрэглээг өрхийн түвшинд нэмсэн нийлбэрээр тодорхойлогдоно.

3. Сууцны хэрэглээ Хүн амын хэрэглээний зайлшгүй нэг хэсэг болох сууцны хэрэглээг тухайн сууцнаас өрхийн гишүүдийн авч байгаа сэтгэл ханамжаар тодорхойлно. Сууцны түрээсийн төлбөрийн хэмжээ нь энэ сууцны сэтгэл ханамжийн үнэлгээ болно. Хөгжиж байгаа орнуудын хувьд сууцны түрээсийн зах зээл хязгаарлагдмал, эсвэл ийм үйлчилгээ байдаггүй учир холбогдох тооцоог хийх, улмаар түүнийг хэрэглээний бүтцэд хамааруулахад нилээд хүндрэлтэй. Сууцны түрээсийн зах зээл хязгаарлагдмал тохиолдолд “хийсвэр

түрээс"-ийн тооцоог хийнэ. Тооцооны түрээсийн утгыг тооцохын тулд регрессийн шинжилгээг ашиглах бөгөөд хамаарагч хувьсагчаар сууцны худалдах үнийг сонгоно. Үл хамаарах хувьсагчдаар орон сууцны нөхцлийг тодорхойлогч шал, хана, дээврийн үндсэн материалын төрөл, өрөөний тоо, усан хангамж, цахилгаан, дулаан, байршил зэргийг авна. Уг тооцоог орон сууцны төрөл тус бүрээр буюу гэр, сууцны тусдаа байшин, нийтийн тохилог сууц, бусад сууцны хувьд тус тусад нь хийнэ. Сууцны үнийг ашиглаж сууцнаас авч байгаа үйлчилгээний тооцоог гаргахад сууцны элэгдлийн түвшинг тодорхойлох шаардлагатай. Сууцны тусдаа байшин болон нийтийн тохилог сууц 33 жилийн дараа, гэр 17 жилийн дараа бүрэн элэгдэнэ гэж тооцно. Хэрэглээний бүтцийг байгуулахдаа сууцнаас авч буй үйлчилгээний тооцоонд сууцны худалдах үнийг ашиглан тооцсон хийсвэр түрээсийг оруулна. Хэрэв тухайн өрхийн хувьд бодит түрээсийн мэдээлэл байгаа тохиолдолд түүнийг ашиглана.

4. Удаан эдэлгээтэй барааны хэрэглээ Өрхийн эзэмшиж байгаа удаан эдэлгээтэй бараа нь хэрэглээний нэг чухал хэсэг юм. Өрхийн удаан эдэлгээт бараанаас авч буй хэрэглээний хэмжээг тухайн барааны үнийн дүнтэй шууд пропорциональ хамааралтайгаар “элэгдлийн түвшин” гэсэн үзүүлэлтээр (мөнгөн илэрхийллээр) тодорхойлно. Бараа бүрийн элэгдлийн түвшинг тухайн барааны зах зээлийн одооны үнэ, түүнийг ашигласан хугацааны үзүүлэлт дээр үндэслэн тооцно. *(Энд өрхийн бизнест ашиглагдах бараа эсвэл үнэт эдлэл, сууцыг хамааруулахгүй)*. Удаан эдэлгээтэй барааны элэгдлийн түвшинг тодорхойлохын тулд тухайн барааны зах зээлийн нэгжийн үнэ (хувьсах хэмжигдэхүүн), түүнийг ашигласан хугацаанд үндэслэн шугаман регрессийг тооцно. Улмаар тооцож гаргасан удаан эдэлгээт бараа бүрийн элэгдлийн түвшний үзүүлэлтийг өрхийн түвшинд нэгтгэнэ.

5. Түлш, эрчим хүчний хэрэглээ Манай орны эрс тэс уур амьсгалтай холбоотойгоор халаалт болон түлш өрхийн хэрэглээний зайлшгүй нэн чухал хэрэгцээ болж байдаг. Түлш, эрчим хүчний хэрэглээг тооцохдоо монгол орны нүүдлийн соёл иргэншлийн онцлог шинж болох аргал, хөрзөн, мод, түлээгээ өөрсдөө бэлтгэн төлбөргүйгээр хэрэглэдэг онцлогийг тусгана. Халаалт, гэрэлтүүлэгтээ цахилгаан, түлш буюу мод, нүүрс, аргал хэрэглэдэг өрхүүдийн зарцуулсан болон худалдан авсан үнийн дүн нь түлш эрчим хүчний хэрэглээ болох бөгөөд худалдан авалт хийгээгүй өөрсдөө түлшээ бэлтгэдэг өрхүүдийн хувьд түлшний хэрэглээг үнэлж оруулна. Хэрэглээг бүрэн тооцохын тулд түлшээ өөрсдөө бэлтгэсэн өрхүүдийн хэрэглэсэн түлшний тоо хэмжээний мэдээллийг цуглуулна. Өрхийн өөрсдийн бэлтгэж хэрэглэсэн түлшийг үнэлэхдээ уг өрхийн харгалзах түүврийн нэгж дэх тухайн төрлийн түлшийг худалдан авч хэрэглэсэн өрхүүдийн түлшний нэг нэгжид харгалзах медиан үнийг ашиглана. Хэрэв тухайн түүврийн нэгжид уг нэр төрлийн түлшний худалдан авалт хийгдээгүй бол худалдан авалт хийгдсэн түүний дээд түвшний (сум, аймаг, бүс, суурьшил) түүврийн нэгжид харьяалагдах медиан үнийг

ашиглана. Ингээд өрхийн өөрсдийн бэлтгэж хэрэглэсэн түлшний тоо хэмжээг тухайн түлшинд харгалзах медиан үнээр үржүүлж, түлш эрчим хүчний хэрэглээнд оруулна. Эцсийн шатанд хүнсний бус хэрэглээтэй адилаар түлш, эрчим хүчний хэрэглээг сард шилжүүлэх ба өрхийн түвшинд нэгтгэнэ.

### **III.3. Үнийн зохицуулалт**

Бараа, үйлчилгээний үнийн хэлбэлзэл өндөр тохиолдолд судалгааны хамрах хугацаа, судалгааны үр дүнд харьцуулалт хийх онцлог, түүнд хэрэглэж байгаа ангиллын хүрээнд үнийн зохицуулалтыг хийнэ.

Монголд хүнсний бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл өндөр байдаг. Ийм ч учраас амьжиргааны түвшинг бодитойгоор тооцохын тулд зарлагын дүнг үнийн индексийг ашиглан засварлах шаардлагатай.

Үнийн индекс нь хоёр үндсэн хэсгээс тухайлбал *үнэ* болон үнийн тохирох түвшинд харгалзах *төсвийн бүтэц* буюу *хэрэглээний хувийн жингээс* бүрдэнэ. Үнийн ялгааг үнэ болон хэрэглээний бүтцээр индексжүүлснээр тухайн бараа, үйлчилгээний үнээс үнийн ялгааг арилгана.

Түүвэрлэлтийн анхан шатны  $i$  нэгж дэх Паашийн үнийн индексийг дараах томъёогоор тодорхойлно:

$$P_i^p = \left[ \sum_{k=1}^n w_{ik} \left( \frac{p_{ik}}{p_{0k}} \right)^{-1} \right]^{-1}$$

Энд:  $w_{ik}$ - Түүврийн анхан шатны  $i$  нэгжийн  $k$  нэрийн барааны төсөвт эзлэх хувийн жин;

$P_{ik}$ - Түүврийн анхан шатны  $i$  нэгжийн  $k$  нэрийн барааны дундаж үнэ (үнийн медиан)

$P_{0k}$ -  $i$  нэгжийн  $k$  нэрийн барааны улсын дундаж үнийн түвшин (үнийн медиан).

Хүнсний бүтээгдэхүүний хувьд цаг хугацааны болон газар зүйн байршлын засварлалтыг, хүнсний бус бараа, бүтээгдэхүүний хувьд цаг хугацааны засварлалтыг хийнэ.

### **III.4. Өрхийн хэрэглээний бүтэц, хэмжээнд зохицуулалт хийх**

Аж байдлын үзүүлэлтийг тодорхойлох үйл явцын эцсийн шатанд өрхийн түвшинд тодорхойлогдсон амьжиргааны түвшний хэмжигдэхүүнүүдийг нэг хүнд ногдох хэмжээнд шилжүүлнэ. Нэг хүнд ногдох хэмжээнд шилжүүлэхэд өрхийн ам бүлийн бүтэц мөн тухайн өрхийн хэрэглээний эдийн засгийн чадавхи буюу өрхийн гишүүдийн дундын хэрэглээний хэмжээ нөлөөлнө. Өрхийн хэрэглээний бүтэц, хэмжээнд зохицуулалтыг дараах 2 аргаар хийнэ.

1. Өрхийн ам бүлийн бүтцийн зохицуулалт. Өрхийн гишүүдийн нас хүйс, бусад онцлогоос хамааран гишүүд нь янз бүрийн хэрэглээ, хэрэгцээтэй



байхыг харгалзан өрхийн гишүүдийг “жишсэн насанд хүрсэн хүн” гэж томъёолсон нэг хэмжээст шилжүүлнэ. Гэвч дундаж хэмжигдэхүүн тооцож буй ядуурлын олон улсын аргачлалд өрхийн хэрэглээнээс тухайн өрхийн гишүүн бүр ижил хувь хүртэнэ гэж үздэг нэгдсэн практик байдаг. Тиймээс нэг хүнд шилжүүлэх аргыг ашигладаг.

2. Өрхийн хэрэглээний эдийн засгийн чадавхид тулгуурласан зохицуулалт. Өрхийн гишүүдийн дундын хэрэглээний бараа, үйлчилгээг “нийтийн буюу дундын хэрэглээний бараа, үйлчилгээ” гэнэ. Өрхийн нэг гишүүний тухайн барааг хэрэглэх нь нөгөө нэг гишүүний хэрэглэх боломжийг хаахгүй бол тухайн барааг нийтийн буюу дундын гэнэ. Эдгээр барааны жишээ бол сууц, удаан эдэлгээт бараа юм. Өрхийн хэрэглээнд нийтийн хэрэглээний бараа, үйлчилгээний эзлэх хувийн жин өндөр байх тусам тухайн өрхийн эдийн засгийн (хэмжүүр) боломж нь өндөр байна.

Энэ 2 төрлийн зохицуулалтыг дараах томъёоллын дагуу хийнэ.

$$AE=(A + \alpha K)^\theta$$

Үүнд: AE - өрхийн жишсэн хүний тоо.

A - насанд хүрсэн хүний тоо.

K - хүүхдийн тоо

$\alpha$  - хүүхдийг насанд хүрэгчтэй харьцуулсан харьцангуй өртгийг хэмжих параметр

$\theta$  - өрхийн эдийн засгийн хэмжүүрийн зэрэг

Энэ 2 параметрийн утга нь 0-1–ийн хооронд байна.  $\alpha$  болон  $\theta$ -г ямар утгатайгаар авч тооцоонд ашиглах эсвэл хэрхэн шинээр тооцох, энэ нь тооцоонд хэр тохиромжтой эсэхийг тодорхойлсон нэгдсэн арга, аргачлал одоог хүртэл байхгүй маргаантай хэвээр байна. Тиймээс нэг хүнд шилжүүлэх зохицуулалтыг хийхдээ  $\alpha$  болон  $\theta$ -гийн түвшин хоёул нэгтэй тэнцүү буюу хүүхдийн хэрэглээ, насанд хүрсэн хүний хэрэглээнээс ялгаагүй, эдийн засгийн хэмжүүр байхгүй гэж үздэг нэгдсэн стандартыг олон улсад хэрэглэж байна. Энэ жишгийн дагуу өрхийн хэрэглээний хэмжээг ам бүлийн тоонд хувааж нэг хүнд ногдох хэмжээгээр тодорхойлно.

### **III.5. Ядуурлын шугам тооцох арга**

**Ядуурлын шугам** нь тодорхой өгөгдсөн цаг хугацаа, оршин байгаа орчинд хувь хүний амьжиргааны түвшинг мөнгөн дүнгээр илэрхийлсэн утга болно. Ядуурлын шугам нь ядуу хүнийг ядуу бус хүнээс ялгах гол шалгуур үзүүлэлт юм.

Ядуурлын шугам нь хүний эрүүл, идэвхитэй амьдралыг хангахуйц илчлэгтэй хоол тэжээлийн хэрэгцээг тусгасан хэрэглээний хамгийн бага зардал болно. Түүнчлэн, абсолют хэмжигдэхүүн учир аж байдлын адилхан түвшинд байгаа

хоёр хүнийг амьдарч байгаа суурьшлаас нь үл хамааран хооронд нь харьцуулах боломжтой.

Хүнсний хэрэглээний зайлшгүй шаардагдах илчлэгт үндэслэсэн ядуурлын шугамыг тооцоход үндсэн хэрэгцээний зардлын аргыг хэрэглэнэ. Үндсэн хэрэгцээний зардлын арга нь шаардлагатай хэрэглээг тусгасан хэрэглээний сагсанд зарцуулах зардал дээр үндэслэнэ. Хэрэглээний энэ сагсны зардлыг хангах чадваргүй бол тухайн хүнийг ядуу хүн гэнэ. Энэхүү арга нь тухайн хүн уг хэрэглээний сагсыг худалдан авч чадах чадвартай эсэхийг л зөвхөн тодорхойлно. Ядуурлын шугам нь хүнс ба хүнсний бус гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Хүнсний ядуурлын шугамыг тодорхойлохын тулд *Нэгдүгээрт*, хүний эрүүл идэвхтэй амьдралыг хангахад шаардлагатай хүнс, тэжээлийн хэмжээг тодорхойлно. Шаардлагатай хүнс, тэжээлийн хэмжээг жишсэн нэг хүний хоногт авбал зохих илчлэгийг үндэслэн тогтооно. Нэг хүний хоногт авах шаардлагатай илчлэгийн дундаж хэмжээг 2100 ккалориор жишиг болгож авна. *Хоёрдугаарт*, хүнсний сагсанд орох бүтээгдэхүүнийг сонгоно. Хүнсний сагсны бүтцийг байгуулахдаа тухайн орны жишиг болгон авч байгаа хүн амын хүнсний хэрэглээний бүтцийг харгалзан тогтооно. Хүнсний сагсыг бүрдүүлэхийн тулд нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр нь нийт өрхийг ихээс нь бага руу нь эрэмбэлнэ. Энэхүү эрэмбэлсэн хүн амаас доогуур хэрэглээтэй 40 хувийн хүн амын дундаж хүнсний сагсыг сонгож авна. *Гуравдугаарт*, хүнсний сагсны нэр төрөл тус бүрээр нэг хүний хоногт хэрэглэсэн хэмжээг тооцож гаргана. Архи, тамхи нь зайлшгүй хэрэглээ биш, мөн өрхөөс гадуур хэрэглэсэн хүнсний зүйлийн илчлэгийн хэмжээг тодорхойлоход маш их бэрхшээлтэй байдаг тул архи, тамхи, өрхөөс гадуур хэрэглэсэн хүнсний хэрэглээг тооцоонд хамруулахгүй. *Дөрөвдүгээрт*, нэг хүний хоногт хэрэглэсэн хэмжээнд зарцуулагдаж байгаа ккалорийн хэмжээг хүнсний сагсны нэр төрөл болгоноор тогтооно. Үүнд хүнсний сагсыг илчлэгийн хэмжээгээр тодорхойлохдоо хүнсний бүтээгдэхүүний илчлэгийн үзүүлэлтийг ашиглана. Энэ үзүүлэлтийг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс тогтоодог. *Тавдугаарт*, хүнсний сагсны нийт илчлэгийн хэмжээг тооцож түүндээ үндэслэн хоногт нэг хүн 2100 ккалори авахаар хуваарилна. *Зургаадугаарт*, хүнсний сагсны нэр төрөл болгоноор нэгжийн үнийг тооцно. Нэгжийн үнийг тооцохдоо зөвхөн хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн хүн амын мэдээлэлд тулгуурлана. *Долдугаарт*, нэг ккалорийн голч үнийг тооцож, хоногт 2100 ккалори илчлэгийг авахад зарцуулах мөнгөн дүнг тооцож гаргана.

Жишээ: Нийт өрхийн хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн нэг хүнд ногдох хоногийн дундаж илчлэгийн хэмжээ - 1392 ккал, нэг хүний хоногийн хүнсний сагсны зардал - 1376 төгрөг байсан.

Эндээс нэг хүнд ногдох хоногийн хүнсний ядуурлын шугам

$$(1376 \times 2100) / 1392 = 2076$$

төгрөг болох бөгөөд нэг хүнд сард ногдох хүнсний ядуурлын шугам нь  $2076 * (365/12) = 63110$  төгрөг болж байна.

Хүнсний бус ядуурлын шугам нь эрүүл байж, нийгмийн амьдралд оролцох боломжтой байхын тулд сууц, хувцас, эрүүл мэнд, амралт, чөлөөт цагийн хэрэглээ гэх мэт зайлшгүй шаардлагатай зүйлд зарцуулж буй зардал болно. Дэлхийн банкны арга зүйг ашиглан хүнсний бус ядуурлын шугамыг байгуулна. Эхний алхамд ядуучуудыг төлөөлөх жишиг бүлгийг сонгож хүнсний бус зүйлд уг бүлгийн гаргаж буй зардлыг тооцоолно. Үүнд: *Нэгдүгээрт*, хүнсний зардал нь хүнсний ядуурлын шугамтай тэнцүү байгаа хүн амын нийт хэрэглээнд нь эзлэх хүнсний хувийн жинг тодорхойлж тогтооно. Хүнсний ядуурлын шугамаас нэмэх, хасах нэг хувийн хооронд хүнсний хэрэглээтэй өрхийн хүнсний хувийн жинг тооцно. Үүнийг нэмэх, хасах хоёр хувь, гурван хувь гэх мэтээр арван хувь хүртэл давтан үйлдэнэ. *Хоёрдугаарт*, эдгээр арван хувийн жинг дундажлан нийт зардалд эзлэх хүнсний хувийн жинг эцэслэн тооцно. *Гуравдугаарт*, энэ хувийн жинг үндэслэн хүнсний бус хэрэглээний хувийн жинг тодорхойлж, нийт ядуурлын шугамыг тооцно. Энэ нь тухайн хүн эрүүл амьдрахад шаардлагатай зардлыг хүнсэндээ гаргаж байгаа бол мөн амьдрахын тулд бусад зайлшгүй шаардлагатай хүнсний бус зүйлийг хэрэглэдэг гэсэн таамаглалд үндэслэдэг. Энэ аргаар хүнсний бус хэрэглээг нь тодорхойлсон ядуурлын шугамыг ядуурлын дээд шугам гэнэ.

Доод ядуурлын шугамын арга зүй дээд ядуурлын шугам тооцохтой төстэй боловч нэг ялгаа нь нийт хэрэглээ нь хүнсний ядуурлын шугамтай тэнцүү хүн амыг жишиг бүлгээр сонгоно. Түүнчлэн хүнсний ядуурлын шугамыг хүнсний хувийн жинг хоёроос хассан ялгавраар үржүүлж, ядуурлын доод шугамыг мөн тооцож гаргана. Үүнийг ядуурлын туйлын доод босго гэнэ.

Жишээ: Хүнсний зардал нь хүнсний ядуурлын шугамтай тэнцүү байгаа хүн амын нийт хэрэглээнд эзлэх хүнсний хувийн жингийн дундаж нь 42,5 хувь, нийт хэрэглээ нь хүнсний ядуурлын шугамтай тэнцүү байгаа хүн амын нийт хэрэглээнд эзлэх хүнсний хувийн жингийн дундаж нь 54,3 хувь, хүнсний ядуурлын шугам нь 63110 төгрөг байсан.

Эндээс ядуурлын дээд шугам:  $63110 / (42,5/100) = 148494$  төгрөг

ядуурлын доод шугам:  $63110 / (54,3/100) = 116225$  төгрөг

ядуурлын туйлын доод шугам:  $63110 * (2 - 54,3/100) = 91951$  төгрөг болно.

### Ядуурлын шугамыг хэрэглээний үнийн индексээр индексжүүлэх

Ядуурлын дүр төрх хэрхэн өөрчлөгдөж байгааг урт хугацаанд харах, харьцуулах боломжийг хангахын тулд суурь оны ядуурлын шугамыг үнийн өөрчлөлтөөр индексжүүлэх аргыг хэрэглэнэ. Суурь болгож авсан аль нэг оны ядуурлын шугамыг үндсэн хэрэгцээний зардлын аргаар тооцсон байна. Индексжүүлэх арга нь тухайн хүний хэрэглэж буй бараа үйлчилгээний сагсны

бүтцэд ямар нэгэн өөрчлөлт ороогүй тогтмол гэж үзвэл хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтөөс хамааран амьжиргааны байдал нь хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулдаг. Уг аргаар тооцоо хийхдээ ядуурлын шугамын хүнс, хүнсний бус хэсгийг тус тусад нь индексжүүлнэ. Хүнсний ядуурлын шугамыг тооцохдоо суурь оны хүнсний ядуурлын шугамыг тухайн оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллээс тооцсон хүнсний барааны үнийн өөрчлөлтөөр (Фишерийн индекс) индексжүүлнэ. Хүнсний бус ядуурлын шугамыг тооцохдоо хэрэглээний үнийн индексийн хүнсний бус барааны бүлгийн индексийг (Ласпейресийн индекс) ашиглана. Эцэст нь ядуурлын шугам нь хүнс, хүнсний бус ядуурлын шугамын нийлбэрээр тодорхойлогдоно. Суурь болгож авсан ядуурлын шугамыг шаардлагатай тохиолдолд ӨНЭЗС-ны дүнд үндэслэн шинэчилнэ. Эдийн засгийн огцом өөрчлөлттэй холбоотойгоор хүн амын хэрэглээний бүтцэд их хэмжээний өөрчлөлт гарсан тохиолдолд ядуурлын суурь шугамыг шинэчлэх чиглэл баримтална.

Жишээ: Суурь оны ядуурлын шугам - 116225 төгрөг  
 Хүнсний ядуурлын шугам – 63110 төгрөг  
 Хүнсний бус ядуурлын шугам – 53115 төгрөг  
 Хүнсний Фишерийн индекс – 1,172  
 Хүнсний бус Ласпейресийн индекс – 1,215 байсан.

Эндээс тухайн оны ядуурлын шугам:  
 $63110 \cdot 1,172 + 53115 \cdot 1,215 = 73965 + 64535 = 138500$  төгрөг байна.

### **III.6. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох**

**Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд /хэмжүүрүүд/.** Ядуурлын хэмжүүрийн талаар олон эрдэмтэн, судлаачийн бүтээл, ном, товхимол байдаг хэдий ч ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлоход Фостер, Грээр, Торбек нарын 1984 онд боловсруулсан ядуурлын хэмжүүрийг түлхүү ашиглахыг Дэлхийн банк улс орнуудад зөвлөдөг.

Энд ядуурлын хэмжүүрийг дараах нэгдсэн томъёогоор тодорхойлно.

$$P_{\alpha} = \frac{1}{n} \sum_{i=1}^q \left( \frac{z - y_i}{z} \right)^{\alpha}$$

Энд  $\alpha$  – эерэг параметр,  
 $z$ - ядуурлын шугам,  
 $y$ - хэрэглээ,  
 $i$ - хувь хүн  
 $n$ - ерөнхий олонлогт байгаа нийт хүн амын тоо  
 $q$ - ядуурлын шугамаас доош хэрэглээтэй хүний тоо

**Ядуурлын хамралтын хүрээний индекс ( $\alpha = 0$ ).** Энэ хэмжүүр нь нийт хүн амын тоонд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь хэмжээг илэрхийлнэ. Энэ хэмжүүр нь “хувиар” тодорхойлогдоно.

$$P_0 = \left(\frac{1}{n}\right) \sum_{i=1}^q \left(\frac{z - y_i}{z}\right)^0 = \frac{q}{n}$$

**Ядуурлын гүнзгийрэлтийн индекс ( $\alpha = 1$ ).** Энэ хэмжүүр нь ядуучуудын хэрэглээний дундаж хэмжээ нь ядуурлын шугамаас хэр зэрэг доогуур байгааг илэрхийлнэ. Энд хэрэглээний дутагдал, хомсдол их байх тутам гүнзгийрэлт өндөр байна. Энэ хэмжүүр нь “хувиар” тодорхойлогдоно.

$$P_1 = \frac{1}{n} \sum_{i=1}^q \left(\frac{z - y_i}{z}\right)^1$$

**Ядуурлын мэдрэмжийн индекс ( $\alpha = 2$ ).** Ядуучуудын дундах хэрэглээний тархалтын мэдрэмжийг илэрхийлнэ.

$$P_2 = \frac{1}{n} \sum_{i=1}^q \left(\frac{z - y_i}{z}\right)^2$$

Ядуучуудын хооронд хийгдсэн шилжүүлгүүдийн үр дүнд ядуурлын хамралтын хүрээ, ядуурлын гүнзгийрэлт өөрчлөгдөхгүй, харин мэдрэмж өөрчлөгдөнө. Ядуурлын гүнзгийрэлт их байх тутам ихээр жигнэгдэж нөлөөлнө. Жишээг Хавсралт 1-т оруулав.

**Жини коэффициент (G)** – Энэ хэмжигдэхүүн нь хүн амын хэрэглээний тэнцүү бус хуваарилалтыг илэрхийлсэн коэффициент юм. Жини коэффициентийг дараах томъёогоор тодорхойлно.

$$G = 1 - 2 \sum_{i=1}^n x_i c_{i1} y_i + \sum_{i=1}^n x_i y_i$$

Үүнд:  $x_i$  - нийт хүн амд ( $i=1$ ) бүлгийн хүн амын эзлэх хувийн жин.

$y_i$  - ( $i=1$ ) бүлгийн хүн амын хэрэглээний хувийн жин;

$n$  - бүлгийн тоо;

$c_{i1}$  - орлогын хувийн жингийн өсөн нэмэгдэх дүн.

Жини коэффициент нь 0-1-ийн хооронд утга авна. Жини коэффициент нэг гэсэн утганд ойртох тутам хэрэглээний тэнцүү биш байдал өндөр байгааг илтгэнэ. Харин энэ коэффициент нь 0-тэй тэнцүү бол орлогын хуваарилалтанд

ялгаа бараг байхгүй буюу ийм тохиолдолд ядуурал байхгүй байгааг илэрхийлнэ. Жишээг Хавсралт 2-т оруулав.

### **III.7. Мэдээллийн эх үүсвэр, мэдээллийн боловсруулалт, тооцоонд хэрэглэгдэх үндсэн ангилал**

Ядуурлыг хэмжих, дүн шинжилгээ хийх судалгааны мэдээллийг хэд хэдэн эх үүсвэрээр цуглуулж болно. Үүнд:

1. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
2. Хэрэглээний үнийн судалгаа
3. Нийгмийн үзүүлэлтийн бусад судалгаа

#### **Мэдээллийн боловсруулалт**

Мэдээллийн боловсруулалт цэгцтэй дарааллаар, төвлөрсөн байдлаар хийгдэнэ. Мэдээллийн үзүүлэлт хоорондын уялдааны шалгалтыг гурван үе шатанд хийнэ. Нэгдүгээрт, мэдээлэл шивж оруулахад Хоёрдугаарт, тоо мэдээллийг боловсруулахад Гуравдугаарт, үр дүнг тооцож гаргахад тус тус хийнэ. Мэдээллийн эх үүсвэрийг бодлогын даалгаврын хүрээнд тусгайлан боловсруулсан хэрэглээний пакет программ CPro-д шивж оруулах бөгөөд, статистикийн шинжилгээний “STATA” программаар боловсруулна.

#### **Ядуурлын тооцоонд хэрэглэгдэх үндсэн ангилал, бүлэглэлт**

Судалгааны хамрах хүрээ, зорилгоос хамаарч ядуурлын судалгааны мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээнд дараах ангилал, бүлэглэлтийг хэрэглэнэ. Үүнд:

#### **А. Ангиллууд:**

1. Бүс нутгийн ангилал (Бүс нутгийн хөгжлийн баримт бичигт тусгагдсан бүсээр)
2. Боловсролын түвшний ангилал
3. Ажил эрхлэлтийн салбарын ангилал
4. Ажил мэргэжлийн ангилал
5. Өвчлөлийн ангилал
6. Хувийн хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал (COICOP)

#### **Б. Бүлэглэлтүүд:**

1. Байршлаар
2. Суурьшлаар
3. Хүйсээр
4. Насны бүлгээр

5. Хэрэглээний бүлэглэлтээр. Бүлэглэлт нь хүн амын хэрэглээний ялгааг судлах боломжийг олгоно.
- 5.1 Хэрэглээний тэнцүү 5 бүлгээр: *Нэг хүн амд ногдох хэрэглээг үндэслэн хүн амыг хэрэглээний 5 тэнцүү бүлэгт хуваана (20%; ...20%).*
- 5.2 Хэрэглээний тэнцүү 10 бүлгээр: *Нэг хүн амд ногдох хэрэглээг үндэслэн хүн амыг хэрэглээний 10 тэнцүү бүлэгт хуваана (10%; ...10%).*

Жишээ: Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох

Өрхийн дугаар (n)	Нэг хүнд ногдох хэрэглээ (y)	Ядуурлын шугам (z)	Ядуу өрх (ядуу-1 ядуу бус-0)	$\frac{z - y_i}{z}$	$\left(\frac{z - y_i}{z}\right)^2$
1	130 013	116 225	0		
2	115 421	116 225	1	0.007	0.00005
3	76 414	116 225	1	0.343	0.11733
4	37 455	116 225	1	0.678	0.45933
5	172 498	116 225	0		
6	56 140	116 225	1	0.517	0.26726
7	66 626	116 225	1	0.427	0.18211
8	148 305	116 225	0		
9	120 688	116 225	0		
10	139 385	116 225	0		
11	52 910	116 225	1	0.545	0.29676
12	103 370	116 225	1	0.111	0.01223
13	183 038	116 225	0		
14	142 444	116 225	0		
15	174 912	116 225	0		
16	150 297	116 225	0		
17	237 981	116 225	0		
18	149 227	116 225	0		
19	119 362	116 225	0		
20	147 636	116 225	0		
<b>Нийт</b>			<b>7</b>	<b>2.626</b>	<b>1.335</b>

**Ядуурлын хамралтын хүрээний индекс ( $\alpha = 0$ ).**

$$P_0 = \left(\frac{1}{n}\right) \sum_{i=1}^q \left(\frac{z-y_i}{z}\right)^0 = \frac{q}{n} \Rightarrow 7 / 20 = 0.35$$

**Ядуурлын гүнзгийрэлтийн индекс ( $\alpha = 1$ ).**

$$P_1 = \frac{1}{n} \sum_{i=1}^q \left(\frac{z-y_i}{z}\right)^1 \Rightarrow 2.626 / 20 = 0.13$$

**Ядуурлын мэдрэмжийн индекс ( $\alpha = 2$ ).**

$$P_2 = \frac{1}{n} \sum_{i=1}^q \left(\frac{z-y_i}{z}\right)^2 \Rightarrow 1.335 / 20 = 0.07$$



Жишээ: Жини коэффициент тооцох

Өрхийн дугаар (n)	Нэг хүнд ногдох хэрэглээ*	Хүн амын эзлэх хувийн жин (x)	Хэрэглээний хувийн жин (y)	Хэрэглээний хувийн жингийн өсөн нэмэгдэх дүн cum(y)	x*cum(y)	x*y
4	37,455	0.05	0.015	0.015	0.001	0.001
11	52,910	0.05	0.021	0.036	0.002	0.001
6	56,140	0.05	0.022	0.058	0.003	0.001
7	66,626	0.05	0.026	0.084	0.004	0.001
3	76,414	0.05	0.030	0.115	0.006	0.002
12	103,370	0.05	0.041	0.156	0.008	0.002
2	115,421	0.05	0.046	0.201	0.010	0.002
19	119,362	0.05	0.047	0.249	0.012	0.002
9	120,688	0.05	0.048	0.296	0.015	0.002
1	130,013	0.05	0.052	0.348	0.017	0.003
10	139,385	0.05	0.055	0.403	0.020	0.003
14	142,444	0.05	0.056	0.460	0.023	0.003
20	147,636	0.05	0.058	0.518	0.026	0.003
8	148,305	0.05	0.059	0.577	0.029	0.003
18	149,227	0.05	0.059	0.636	0.032	0.003
16	150,297	0.05	0.060	0.696	0.035	0.003
5	172,498	0.05	0.068	0.764	0.038	0.003
15	174,912	0.05	0.069	0.833	0.042	0.003
13	183,038	0.05	0.073	0.906	0.045	0.004
17	237,981	0.05	0.094	1.000	0.050	0.005
<b>Нийт</b>	<b>2,524,124</b>	<b>1.00</b>	<b>1.000</b>		<b>0.418</b>	<b>0.050</b>

\* -Өгөгдсөн өрхүүдийг нэг хүнд ногдох хэрэглээгээр нь эрэмбэлнэ.

**Жини коэффициент (G)**

$$G = 1 - 2 \sum_{i=1}^n x_i \text{cum} y_i + \sum_{i=1}^n x_i y_i \quad \Rightarrow \quad 1 - 2 * 0,418 + 0,050 = 0.215$$